

# ХҮЧТЭЙ ТӨРИЙН НОМЛОЛЫН ЭРГЭН ТОЙРОНД

Ю.Атар МУБИС. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D), дэд профессор

Түлхүүр үг: хууль, хүчтэй удирдагч, улс төрийн лидерүүд, хүчтэй засаглал,

## Үндэслэл

Монгол оронд өrnөж буй нийгэм эдийн засгийн шинэчлэлийн аль нэг хүчин төрийг хүчгүйдүүлэх замаар улдаан зогсоох, тоглоом тохуу хийн төрийг барьцаалах, мушгин гүйвулах, гүтгэлэг зохиож, ингэснээр ардчиллын үнэ цэнийг нийгмийн ухамсарт муу муухай зүйл болгон харуулах гэж зорьж ирлээ.

Төрийн бүхий л албан тушаал, ялангуяа шийдвэр гаргах түвшинд зөвхөн өөрийн хүмүүс байх ёстай гэж үзэн, тухайн хүний мэдлэг боловсрол, туршлагыг хойш нь тавьсаар ирлээ. Худал хэлэх, худал амлах, баримжаагүй гордох, гүтгэн доромжлох, шамшигдуулан идэх, ялгаварлан гадуурхах зэрэг жирийн хүнд байдаг ёс суртахууны хэмжүүрийг тоохон болилоо.

Хууль бүгдэд шударгаар үйлчлэх ёстай. Төрийн хуулийг зөрчсөн хэн ч боловч ял шийтгэлээ хүлээх ёстай билээ. Эс чингэвээс энэ нь нийгэмд ёс заншил болон хувирч, эрх зүйт төр оршихын утгыг алдагдуулна.

## Хүчтэй улс төрийн удирдлагын онол

Энэхүү онол бол улс төрийн философиийн нэг баримтлал мөн. Улс төрд, улс төрийн лидерүүд гол үүрэг гүйцэтгэнэ гэсэн томъёолол дээр энэ онол тулгуурлажээ. Хүчтэй удирдагч, улс төрийн хүчтэй лидерүүд, хүчтэй улс төр, хүчтэй засаглал зайлшгүй шаардлагатай байна. Ард түмэн ардчиллаа аврахын тулд улс төрийн хүчтэй лидерүүдтэй байхыг хүсч байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн элитүүд ард олноо захирч захиргаадахыг, хүн ардыг хатуу гараар барихыг зөвшөөрнө гэсэн үг юм. Элитүүдийн халаа сэлгээ хийх нь улс төрийн өөрчлөлтийг илтгэж харуулна. Зальтнуудын бүлэглэл нь улс төрийн хов живийн аргаар зөвшилд хүрэх чадалтай ч гэсэн хүчирхийллийг хэрэглэх авьяас үгүй гэжээ. Үүнээс голлон шалтгаалж зальтнуудын бүлэглэлийг халж, түүний оронд эрс шийдвэртэй зоримог алхам хийж чаддаг хүчтэнүүдийн бүлэглэл засгийн эрхийг гартаа оруулж авах нь чухал байна. Ийм гольдирлоор элитүүдийн халаа сэлгээ явагддаг болохыг В.Парето сургаж байв. Ардчилсан дэглэмийн удирдагчид нь цөмөөрөө панзчингууд байдаг. Тийм ч учраас ардчилал нь авилгалд өртсөн улс төрийн ялзармал дэглэм мөн гэж В.Парето ч тодорхойлон тэмдэглэсэн нь санамсаргүй зүйл биш бололтой.

Улс төрийн элитүүд төрт ёсны хэм хэмжээнээс даварч ард олныг хараат байдалдаа оруулах санаархлаа хэрэгжүүлж эхлээд байна. Энэ нь олон түмнийг хэт дуулгавартай болгох үүд хаалгыг нээдэг юм. Ийнхүү бие даасан сэтгэхгүйгээ гэсэн, үлэмжийн дуулгавартай ард олон төлөвшиж эхэлнэ. Ингэж улс төрийн амьдралд үл оролцогч ард түмэн бий болно. Зөвхөн ийм л нөхцөлд хүчтэй улс төрийн удирдлага үйл ажиллагаагаа явуулах боломжтой гэж сургадаг болжээ.

Хүн ардын боловсрол дээшлэх, улс төрийн ухамсар төлөвшин, улс төрийн удирдлагын таашаалыг хүлээдэггүй бөгөөд ийм хүн ардын эсрэг эвсэл, хүчирхийлэл эсвэл ов мэх хэрэглэх шаардлага улс төрийн лидерүүдийн дунд гарч ирнэ. Үүнээс үүдэн улс төрийн лидерүүд төр засгийн чадвар гэсэн ойлголтыг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн томъёолохыг оролддог юм. Улс төрийн лидерүүдийн дэвшүүлдэг ийм үзлийг тодруулбал, улс төрийн удирдлагын нэгэн далд түлхүүр гэж үзэж болох талтай.

Улс төрийн лидерүүд нь нийгэм-түүхийн үйл явцыг бүтээгчид мөн гэж Ч.Мерриан томъёолсон. Тэрээр улс төрийн лидерүүдийг турван ангилалд хуваан үзжээ. Нэгдүгээр ангилал нь өөрийн заль мэхээр засаглалыг авч улс төрийн чадал тэнхээтэй болсон лидерүүдийг хамран оруулжээ. Хоёр дахь ангилал нь оюун ухаанаараа хүчтэй удирдагчийг, гурав дахь ангилал нь зохион байгуулах чадвартай лидерүүдийг оруулсан байна. Эдийн засгийн шалтгаан нь биш, чухамдаа лидерүүдийн эр зориг л улс төрийн бодит байдлыг илчилж харуулах түлхүүр нь мөн гэж Ч.Мерриан тодорхойлсон байдаг. Улс төрийн хүч нь нийгэм-түүхийн үйл явцын гол хүчин зүйл нь болж явдаг учраас нийгэм-эдийн засгийн хямралаас, эдийн засгийн бодит амьдралаас хараат биш байдлаар оршин тогтоож чаддаг юм гэжээ. Их хүчний түрэлтийн энэ хандлага нь нийгмийн түүхэнд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг учраас тэрээр нийгэм эдийн засгийн амьдралд, соёлын хүрээнд, улс төрийн практикт өөрөө өөртөө дардан замаа нээж чаддаг гэсэн томъёололыг Ч.Мерриан дэвшүүлсэн байна.

Төр засгийн чадвар гэсэн ухагдахууныг улс төрийн удирдлага улс орны хувь заяаны асуудалтай биш, харин огт өөр асуудалтай холбож тодорхойлдог. Чухамдаа улс төрийн элитүүдээс хүчирхийлэл, өв мэх хоёрыг хослуулж ашиглах чадвар нь улс оронд улс төрийн ноёрхолыг тогтоох, төр засгийн тэрхүү чадамжийн гол шалгуур нь болж өгдөг байна. Энэ шалгуураар төрийн өндөрлөгүүдэд шударга хүмүүсийг дэвшүүлэх ёстой. Тэгээд ч хүчтэй улс төрийн удирдлага ардчилалын томъёололоор өөрийнхөө засаглалыг өндөрт өргөх нь зүй ёсны асуудал билээ. Өөрөөр хэлбэл өөдгүй, явуургүй, урагшгүй лидерүүдийг халж зайлцуулах, шинэ лидерүүдийг улс төрийн тавцанд дэвшүүлж тавихыг олон түмэн шаардаж эхэллээ.

### Хүчтэй засаглалын номлол

Энэ номлол нь хүчтэй улс төрийн удирдлагын онолтой олон чиглэлээр холбогддог ч гэсэн бие даасан улс төрийн онолын урсгал болон

гарч ирсэн. Хүчтэй засаглал нь XX зууны улс төрийн гол үзэгдэл байх болно гэсэн томъёоллыг эл номлол баримталдаг. Хүн бол улс төрийн хүчинүүдийн гарч байдаг сохор хүүхэлдэй юм. Өөрөөр хэлбэл, хүн улс төрийн ямар ч эрх мэдэлгүй амьтан мөн гэжээ. Хүчтэй засаглалын өөрийнх нь зорилго бодлогын дагуу улс төрийн үйл явцыг бүтээх чадвартай гэсэн үзлийг энэ номлол дэвшүүлжээ. Энэ үзэлд волюнтаризм бүрэн илрэлээ олов. Бас этатизм хүчтэй засаглалын номлолд илэрч байдгийг олж харах хэрэгтэй юм. Тухайлбал төрийн аппарат ард түмний дээр байх ёстой бөгөөд хөдөлмөрчин олныг атган барьж байх учиртай гэжээ. Үүнээс гадна хүнд суртал ч гэсэн хүчтэй засаглалын номлолд томоохон байр суурийг эзлэх болсон. Өнөөгийн нийгэмд хүнд суртал зайлшгүй шаардлагатай. Хүнийг төр улсын иргэний түвшинд биш, хамжлагын түвшинд байлагах нь чухал. Хүний эрх чөлөөг хязгаарлах шаардлагатай. Ийм үзэл нь хүнд суртлын илрэл болж байдаг байна.

Хүчтэй засаглалын номлолд бас нэг чухал томъёолол тусгагдсан. Түүнийг дурьдвал сүм хийдийн гарч шинжлэх ухаан, хүн амын сэтгэл зүй аттагдана, цөөнхийн мэдэлд хэвлэл мэдээлэл байна. Төрийг, армийг гол удирдагч манлайлна. Харин хөдөлмөрчид нь арчаагүй хүүхэлдэйн статустай байх болно хэмээсэн томъёолол гарч ирсэн. Хүчтэй засаглалын онолд дээр дурьдсан чухал асуудлуудаас гадна бас өөр үзэл агуулагдаг болсон. Энэхүү үзэл нь хүн, төр, лидерүүдтэй холбоотой асуудал юм. Үүнтэй уялдаж лидерүүдээр удирдуулсан төр засгийн бэхжилтийн модель гарч ирж байгаа. Уг модель нь хүний бие даасан хөгжлийг биш, харин төрийн бэхжилт лидерүүдийн хөгжлийг онцгойлон анхаарсан. Төрийн бэхжилт, лидерүүдийн хөгжил нь нийгмийн шинэ дэг ёсиг төлөвшүүлж чадна гэж нотолдог. Нийгмийн ийм дэг ёс нь шинэ маягийн хүнд суртлын, шинэ маягийн хуарансаг нийгмийг бий болгоно.

Энэхүү нийгэм нь төр засгийг эдийн засгийн ахуйгаас, нийгэм ангийн бүтцээс дээгүүр тавьж өргөмжилдөг онцлоготой. Үүнээс үүдэн төр засгийн бие даасан шинжийг нийгмийн зүй тогтол хэмээн өргөмжилсөн. Эл зүй тогтолын дагуу хүчтэй засаглал нь ард түмнээсээ салж холддог шинэ маягийн хүнд сурталт төр болон хувирна. Хүчтэй засаглалыг, түүний төрч ухааныг бишрэх ёс төлөвших бөгөөд лидерүүд ийм үзлийгээ ажил хэрэгч, эр зоригийн гүн ухаан хэмээн сурталчилна. Хүчтэй засаглал нь өөрөө лидерүүдийн эрх ашгийг хамгаалсан хүч болон хувирна. Бие даасан сэтгэхүйтэй хүмүүсээ хавчих, иргэдээ гарал үүслээр нь ялгаварлах, элдэв хүчирхийллийн аргыг хэрэглэх зам руугаа хүчтэй засаглал гулсаж ордог. Улс орноо атгаж байхын тулд хүчтэй засаглал нь хүчтэй лидерүүдийн бүлэглэлийг бий болгодог.

М.Вебер дэг журамтай ардчилалын төлөө, хүчтэй парламентын төлөө гэсэн үзлийг баримталсан байдаг. Засаглал төрөлхийн том түшмэдүүдийн болон лут улс төрчдийн гарч байх ёстой гэж М.Вебер сургаж байна. Түшмэлтний засаглал нь өнөө үеийн аль ч төрд үйлчилдэг социологийн гол зүй тогтол болж хувирсан хэмээн М.Вебер номлодог. Тэрээр XX зууны эрх ёст төрүүдийн нийгмийн амьдралд хүнд сурталжуулалт тун эрчимтэй өрнөснийг бий болгоход хүргэж байна. Ардчилал нь нэгэн

өвөрмөц уршигийг төлөвшүүлдэгийг М.Вебер хамгийн түрүүнд ажиглаж мэдсэн. Энэ нь юу вэ гэвэл олон түмнийг нийгэм улс төрийн амьдралд татан оролцуулсанас шинэ шинэ байгууллагуудад «холбоо, эвсэл, нийгэмлэг, хамтлаг» үй олноороо бий болно. Энэ нь арчилсан улс төрийн тогтолцоонд тааламжгүй нөлөө үзүүлдэг уршигтай. Ийм нөхцөлд парламентын ардчилалын сүл талыг хүчтэй удирдагчаар нөхөж сэлбэх шаардлага гарна. Чухамдаа ийм удирдагч бие хүн, нийгэм төрийн харилцааг нааштай зохицуулан шийдэж чадна гэж М.Вебер тодорхойлжээ.

Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт нь нүсэрдэж, шат дамжлага, чирэгдэл зардал ихтэй, үр нөлөө багатай болсны зэрэгцээ үйл ажиллагаа нь зарим тохиолдолд улс төр, явцуу ашиг сонирхлын нөлөөнд өртөж, гажуудсанаас нийгмийн шаардлага, хүлээлтэд нийцсэн үр дүнд хүрч чадахгүй байна. Төр нь авилга, хээл хахууль, хүнд суртал, чирэгдлээс ангид байх ёстой. Засгийн газар нь эдийн засгийнхаа чадамжинд тохирсон цомхон, үр ашигтай байх ёстой билээ.

Аливаа төр, түүний дотор арчилсан төр аппарат дээрээ тогтдог. Аппарат бол байнгын мэргэшсэн, тогвортой чадамжтай байж улс орон хөгжине. Өөрөөр хэлбэл төрийн мэргэжисэн албыг улс төрийн үзэл суртлаас хол хөндий байлгах асуудал хурцаар тавигдаж байна.

### Дүгнэлт

Орчин үеийн улс төрийн бодлого нь төрийн эрх мэдлийг хязгаарлах, олон нийтийн зөв зүйтэй гэж үзсэн үйл хэрэгт үйл ажиллагаагаа хандуулах, засаглалын хуулийн хүрээнд хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна.

Хүчтэй төр гэдэг нь олон цагдаагийн хүчээр хүмүүсийг баривчилж чаддаг төрийг хэлдэг юм биш. Харин слон нийтийн өмнө нээлттэй байж чаддаг төрийг хэлдэг болов уу. Ингэж төр нь хүчтэй байж гэмээнээ монгол улс өөрөө баян чинээлэг тогвортой, ирээдүйдээ итгэлтэй байж чадна.

### Ном зүй

- Бямбаа Д. Монгол улсын төрийн байгуулал, төрийн удирдлагын хөгжил. Өнөөдөр сонин, №172, 2007.07.25,  
Ганхуяг Ш., Гантуяа М, Философийн түүхэн тойм. УБ., 2002  
Гончигдорж Р. Хариуцлагатай төр, чадваржсан бие хүн. Монгол таймс, 2002, №35,36  
Западная философия. М., 2001  
История западная философия. Словарь. М., 1998  
Сайнхишиг Г. Монгол дахь урвуу ардчилал. Философи, эрх зүйн судлал. XXII боть, УБ., 2006, 9-16 дахь тал.  
Монгол дахь ардчиллын хөгжил, төлөв хандлага, зорилт. Ардчилал, №25/05  
Философийн түүх. I хэсэг. Орчуулсан Ү.Нямдорж, УБ., 2002